

**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
2021 ОНЫ 03 ДУГААР САРЫН ЭХНИЙ 14 ХОНОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021 оны 03 дугаар сарын 11

Улаанбаатар хот

№	Хийгдсэн арга хэмжээ	Зорилтот түвшин	Хэрэгжилт
Нэг. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд			
	Захиргааны чиглэлээр	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүлэх	<p>Монгол Улсын цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 41 дүгээр тогтоолыг үндэслэн цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн иргэдийн жагсаалтыг гаргасан.</p> <p>Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/68 дугаар “Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалтын арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжийг 02 дугаар сарын 25-ны өдрийн 04/326 тоот албан бичгээр Эрүүл мэндийн төвд хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн хэмжээнд зорилтот бүлгийн 10690 иргэнийг коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалтад хамруулахаас 03 сарын 10-ны өдрийн байдлаар 9033 иргэнийг хамруулаад байна.</p> <p>Улсын Онцгой Комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 18 дугаар тушаалаар батлагдсан “Коронавируст халдвар (КОВИД-19) – аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг Дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх хэлтэс, албад, хороодод хүргүүлж хэрэгжилтийг хангаж дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт 5181 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 2021.02.22-2021.02.24-ний хооронд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлж</p>

			<p>ажиллалаа. Мөн түр журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/86 дугаар захирамж гарган хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулж нийт 498 иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журмын дагуу бэлтгэл ажлыг хангасан байдалд хяналт шалгалт хийж ажиллалаа</p> <p>Баянгол дүүргийн 2020 оны ээлжит цэрэг татлагын үзлэгээр өвчний учир цэргийн албанаас түр чөлөөлөгдсөн залуусын эрүүл мэндийн байдлыг сайжруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг эрчимжүүлэх чиглэлээр дүүргийн засаг даргын захирамж гарган, хэрэгжилтэд хяналт тавин өвчний учир цэргийн албанаас түр чөлөөлөгдсөн залуусын судалгааг гарган ЭМТ-д хүргүүлсэн.</p>
2	Хүний нөөцийн чиглэлээр	Сургалтанд хамрагдсан байдал	<p>ЗХЖШ-ын даргын 2021 оны н/21 дүгээр тушаалын дагуу СКШ-ын сургуульд бие бүрэлдэхүүн бүрэн оролцож, сургууль явуулсан тухай тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт 3-р сарын 01-нд хүргүүлсэн. Мөн дүүргийн Засаг даргын ДУБ-ийг шинэчлэн томилох, Цэргийн штабыг бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай захирамжийн төслийг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2021 оны 3-р сарын 3,4-нд Цэргийн штабын дарга, офицеруудын цугларалт болон нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан буудлагын сургалтад оролцсон.</p>

3	Төсөв чиглэлээр	санхүүгийн Төсвийн орлогын төлөвлөгөөг орлогын төрөл бүрээр ханган биелүүлэх
---	--------------------	---

2021 онд дүүргийн төсөвт төвлөрүүлэх татварын хэлтсийн 32,110,900.0 мянган төгрөг, хүү, торгуулийн орлого 2,622,250.0 мянган төгрөг, төсөвт 10 байгууллагын өөрийн орлого 713,150.0 мянган төгрөг, нийт 35,446,300.0 мянган төгрөгийн төсвийн орлогын төлөвлөгөөг сар улирлаар хуваарилж, дүүргийн Засаг даргаар батлуулан орлого бүрдүүлэгч 11 байгууллагуудад хүргүүлэн, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаж байна.

2021 оны 03 сарын 09-ний байдлаар 6,449,538.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөө 70.5 хувийн биелэлттэй байна. Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр авч үзвэл: Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 10 нэр төрлийн орлого 30.3- 92.3 хувийн биелэлттэй байна.

- Үүнд: Үйл ажиллагааны орлогын албан татвараар 310,811.9 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 30.3 хувийн, Хадгаламжийн хүүгийн орлогын албан татвараар 2,928,511.6 мянган төгрөг төвлөрүүлж 92.3 хувийн, Хүү торгуулийн орлогоор 476,342.1 мянган төгрөг төвлөрүүлж, 77.0 хувийн, Хувь хүнээс суутгасан орлогын албан татвараар 1,174,100.7 мянган төгрөг төвлөрүүлж 60.7 хувийн, Улсын тэмдэгтийн хураамжийн орлогоор 215,746.9 мянган төгрөг төвлөрүүлж, 49.6 хувийн, Газрын төлбөр 253,106.7 мянган төгрөг төвлөрүүлж, 50.8 хувийн, Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогын татвараар 774,209.8 мянган төгрөг төвлөрүүлж, 91.1 хувийн, Галт зэвсгийн албан татвараар 11,639.0 мянган төгрөг төвлөрүүлж, 62.3 хувийн, Хог хаягдлын хураамжийн орлогоор 294,948.6 мянган төгрөг төвлөрүүлж, 49.8 хувийн, Төсөвт байгууллагын өөрийн орлогоор 5,294.0 мянган төгрөг төвлөрүүлж 52.7 хувийн биелэлттэй байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр нэгтгэж дараа

			сарын 8-ны дотор холбогдох газруудад хүргүүлж, удирдлагыг шуурхай мэдээллээр ханган, олон нийтэд ил тод мэдээллийн самбар, BGD.MN цахим хуудас болон SHILENDANS.GOV.MN цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.
		Батлагдсан төсвийн хуваарийн дагуу төсөвт байгууллагуудын санхүүжилт олгож гүйцэтгэлд хяналт тавих	2021 оны 03 сарын 09-ний байдлаар орон нутгийн 15 байгууллагад 4,256,788.7 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн тогтмол зардлыг санхүүжүүлэхэд 595,917.7 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн 171 байгууллагад нийт 12,700,124.3 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд 41,085.2 мянган төгрөг, нийт 17,593,915.9 мянган төгрөгийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгосон байна. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүжилтийг багцаар авч үзвэл боловсролын яамны багц төрийн 20, төрийн бус өмчийн 29 сургуульд 6,073,837.9 мянган төгрөг, төрийн 36, төрийн бус өмчийн 65 цэцэрлэгт 5,641,403.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамны багц өрхийн 21 эмнэлэгт 984,883.4 мянган төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу цаг хугацаанд бүрэн олгож, зарцуулалтанд хяналт тавьж ажиллаж байна.
		Дүүргийн хэмжээнд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлд хяналт тавин ажиллах	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх 2,460,100.0 мянган төгрөгийн 9 төсөл арга хэмжээ, 2020-2021 онд он дамжин хэрэгжүүлэх 6 ажилд 703,735.3 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ батлагдсан .Орон нутгийг хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020-2021 онд он дамжин хэрэгжүүлэх 139,933.7 мянган төгрөг, 2021 онд ОНХСангаар хэрэгжүүлэх 5 төрлийн ажлын 800,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан. Барьцаа дансанд 2021 онд 374,522.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

		Төсөвт байгууллагын орлого зарлагын гүйлгээг хянан баталгаажуулах	2021 оны 03 дугаар сарын 09-ний байдлаар дүүргийн төрийн сан банкинд байршдаг дансаар орлогын 15,134,175.1 мянган төгрөг, 3291 ширхэг төлбөрийн хүсэлт баримтаар 21,417,075.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулан нийт 36,551,250.3 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна.
		Шилэн дансны тухай хуулийн дагуу SHILENDANS.GOV.MN болон BGD.MN цахим хуудас, мэдээллийн самбарт шинэчлэн байршуулж олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж ажиллах	“Шилэн дансны тухай” хуулийн дагуу SHILENDANS.GOV.MN, BGD.MN цахим хуудсанд ИТХ-ын дүүргийн 2021 оны төсөв батлах тухай 3/05 дугаар тогтоол, 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 01, 02 дугаар сарын төсвийн гүйцэтгэл, орлого, зарлага, өр авлагын мэдээ, мөн төсвийн гүйцэтгэлийн төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар хөрөнгө оруулалтын мэдээг хуулийн хугацаанд байршуулан, БГД-ийн мэдээллийн самбарт тогтмол шинэчлэн, үйл ажиллагаагаа олон нийтэд ил тод болгон ажиллаж байна.
		Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 1 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт бусад холбогдох бичиг баримтыг ХААА-нд хүлээлгэн өгөх	Ваянгол-Агропарк ОНӨТҮГ-ын эко сургуулийн сургалтын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авах ажлын техникийн тодорхойлолтыг ХААА-нд хүлээлгэн өгсөн. Хэрэгжилт: 100%
		Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын төсөл, арга хэмжээний төсвийн задаргаа хийж дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулах	ДТХО-р хэрэгжих бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, тохижилтын ажил 400.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг байршил, ажлын төрлөөр нь 9 төсөл, арга хэмжээ болгон задалж тогтоолын төсөл бэлэн болсон бөгөөд ДИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. Хэрэгжилт: 70%
		Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих төсөл, арга хэмжээний	2021 онд дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний задаргаа бэлэн болсон. ДИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна.

		худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах	Хэрэгжилт:70%
		Нийслэлийн Засаг даргын 2021 оны 01 сарын 29-ны өдрийн А/45 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн 11 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах	Төсөл, арга хэмжээний байршил, төсвийн судалгаа хийгдэж дууссан. Хэрэгжилт: 40%
		Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 сарын 03-ны өдрийн А/129 дугаар захирамжаар эрх шилжин ирсэн 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг хангах	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 24 дүгээр хорооны цогцолбор байр худалдан авах төсөл, арга хэмжээний байршлын судалгаа хийгдэж, ажлын даалгавар боловсруулагдаж байна. Хэрэгжилт: 30%
4	Хууль, эрх зүйн чиглэлээр	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх	Тайлант хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшиж буй 3 иргэний Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн болно.
5	Боловсролын чиглэлээр	Боловсролын ажлын хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр	Багш сурагчдыг цахимаар ажиллах, хичээллэх боломжийг хангах зорилгоор дүүргийн ИТХ-ын санаачлан хэрэгжүүлсэн “Багшаа дэмжье-Цахим хичээлийн дата” аяны хүрээнд багш сурагчдад зориулсан Жи мобайл, Юнител Мобикомын дататай 208 ширхэг сим карт дугаарыг сургуулиудад хүргэх ажлыг зохион байгууллаа. Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021.02.01-ний өдрийн “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” А/35,А/10,9 дугаар хамтарсан тушаалын дагуу сургууль, цэцэрлэгийн төсвийн шууд захирагчийн ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох үүрэг бүхий ажлын хэсгийг

			<p>байгуулах тухай Дүүргийн Засаг даргын А/67 дугаар захирамжийн төслийг боловсруулан батлуулж ажлын хэсгийн хурлыг 03 сарын 01-ний өдөр зохион байгуулав. Мөн тус ажлын хүрээнд захирал, эрхлэгч нарт ур чадварын нэмэгдэл олгох тухай захирамжийн төслийг боловсруулан ажиллаж байна.</p> <p>2020-2021 оны хичээлийн жилийн эрдэм шинжилгээний хурлын “Шилдэг илтгэл” шалгаруулах уралдааныг 2021.03.04-ний өдөр Эрдмийн ундраа цогцолбор сургууль дээр зохион байгуулан нийт бүсээс шалгарсан 76 илтгэл, түүнээс дахин дүүргийн хэмжээнд шалгарсан 12 илтгэлийг танилцуулж шалгуур үзүүлэлтийн дагуу шүүгчдийн бүрэлдэхүүн үнэлгээ зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Илтгэлийн ерөнхий шүүгчдийн үнэлгээгээр дүүргийн 28 дугаар сургуулийн “Цахим хичээлийн сургалтын арга зүй” сэдэвт илтгэл шалгарч улсын хэмжээний шалгаруулалтад оролцох эрхтэй болсон ба илтгэлийн сэдвийн хүрээнд судлагдахуун тус бүрээр амжилттай оролцсон шилдэг 11 илтгэлийг тус бүр шалгаруулан Баянгол дүүргийн Засаг даргын өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаан урамшуулах ажлыг зохион байгууллаа.</p>
6	Эрүүл мэндийн чиглэлээр	<p>Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалтын арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/68 дугаар “Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалтын арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжийг 02 дугаар сарын 25-ны өдрийн 04/326 тоот албан бичгээр Эрүүл мэндийн төвд хүргүүлсэн.</p> <p>Дүүргийн хэмжээнд зорилтот бүлгийн 10690 иргэнийг коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалтад хамруулахаа 03 сарын 09-ний өдрийн байдлаар 5826 иргэнийг хамруулаад байна.</p>

			<p>Коронавируст халдвар (ковид-19)-ын эсрэг вакцины дархлаажуулалтын байнгын 4 цэгийг Ахмадын эмнэлэг, Хүүхдийн эмнэлэг, Төмөр замын нэгдсэн эмнэлэг, UB мед эмнэлэгт, түр цэгийг Эрдмийн ундраа цогцолборын 78 дугаар сургууль, 40 дүгээр сургууль, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Дулааны IV дүгээр цахилгаан станц дээр тус бүр байрлуулан зорилтот бүлгийн иргэдийг дархлаажуулалтад хамруулан ажиллаж байна.</p>
		<p>Өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангах</p>	<p>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрмийг шинэчлэн батлах тухай”, А/04, 2017 оны Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний загвар батлах тухай А/05 дугаар тушаал, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2021 оны “Гүйцэтгэлийн гэрээ байгуулах тухай” А/11 тушаалыг тус бүр үндэслэн Дүүргийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулсан.</p>
		<p>Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах тухай захирамжийн төслийг боловсруулах</p>	<p>Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/90 дүгээр “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээг эрчимжүүлэн ажиллах тухай” захирамжийн төслийг боловсруулан 04/428, 429 тоот албан бичгээр хороодын Засаг даргын ажлын алба, Эрүүл мэндийн төвд тус бүр хүргүүлэн ажилласан.</p>
7	Соёл урлаг, биеийн тамир спортын чиглэлээр	Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамир спорт заалны	Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Нийслэлийн өрөнхий боловсролын нийт 23 сургуулийн спорт заалны талбайн хэмжээ болон тохижилтын талаарх

		нарийвчилсан судалгааг гарган өгөх	нөхцөл байдлын дэлгэрэнгүй судалгаа мэдлээллийг гарган авч тохижилт, засвар үйлчилгээ хийх шаардлагатай байгаа спорт заалны нэгжийн ерөнхий менежерийн хүсэлтийг Нийслэлийн биеийн тамир спортын хороонд Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргаар дамжуулан хүргүүлж ажилласан.
		Биеийн тамир спортын улсын хорооны цахим сургалтад хамрагдах	2021 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Биеийн тамир спортын улсын хорооноос санаачлан зохион байгуулсан “2021 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө” хэлэлцэх цахим асуулгын хуралд Тамгын газрын тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн оролцож өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт бүрэн эсвэл хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн үед биеийн тамир спортын арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах тухай болон спорт клуб, аж ахуйн нэгж байгууллага дахь биеийн тамир спортын хамтлаг, иргэдээс биеийн тамир спортын ажил үйлчилгээг хэрхэн зохион явуулах тухай, биеийн тамир спортын чиглэлээр ажил үйлчилгээ явуулахад анхаарах, халдвар хамгаалал, эрсдлийн зэргийг хэрхэн үнэлж байгаа тухай мэдээлэлтэй танилцсан.
8	Ахмад настан, нийгмийн хамгааллын чиглэлээр	Геронтологийн үндэсний төвөөс ирсэн хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдах.	2021 оны 03 дугаар сарын 04-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн тусламжийг өргөжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцэх цахим уулзалтанд Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийг хамруулан хамтран оролцсон.
		Нийгмийн халамж үйлчилгээний хүрээнд ирүүлсэн өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэн ажиллах	2021.03.04-ны өдөр тус дүүргийн иргэн Б.Оюундэлгэр нь дахин гэр олгож өгөхийг хүссэн өргөдөл илгээснийг өргөдөл гаргагч иргэнтэй утсаар холбогдон Баянгол дүүргийн 2021 оны нэгдсэн төсөвт тусгагдсан зардал байхгүй тул гэр олгох боломжгүй талаар мэдэгдэж нэг удаагийн буцалтгүй

			<p>тусламж олгох саналтай холбогдох материалыг Баянгол дүүргийн Засаг даргад хүргүүлээд байна.</p> <p>2021.03.04-ны өдөр тус дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн Л.Мөнхжаргал нь өөрийн гэсэн орон байр байхгүй учир гэр олгож өгөхийг хүссэн өргөдлийг хүлээн авч утсаар холбогдон Баянгол дүүргийн 2021 оны нэгдсэн төсөвт тусгагдсан зардал байхгүй тул гэр олгох боломжгүй талаар мэдэгдэж нэг удаагийн буцалтгүй тусламж олгох саналтай холбогдох материалыг Баянгол дүүргийн Засаг даргад хүргүүлээд байна</p> <p>2021.03.09-ны өдөр Нийслэлийн төрийн үйлчилгээний нэгдсэн лавлагаас ирүүлсэн иргэн Д.Баттөр-ийн гаргасан гомдлыг хүлээн авч хорихоос суллагдсан иргэнд нэг удаагийн тэтгэмж олгох журмын дагуу амжиргааны түвшинг тогтоох судалгаа явуулахад 409-ээс дээш оноо авч Нийгмийн халамжийн тухай хуульд заасан тэтгэмж олгох шаардлагыг хангаагүй байх тул боломжгүй талаар утсаар мэдэгдэж ажилласан.</p> <p>2021.03.10-ны өдөр тус дүүргийн иргэн Ч.Туулын Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа “1000 айлын түрээсийн орон сууц” хөтөлбөрийн эхний ээлжинд ашиглалтанд орох 100 айлын нэрсийн жагсаалтанд багтааж өгнө үү гэх утга бүхий өргөдлийг хүлээн авч танилцан холбогдох журмын дагуу шийдвэрлэж хариуг утсаар мэдэгдэж ажилласан.</p>
		<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үнэмлэхийг түргэн шуурхай олгох, сунгалт хийх</p>	<p>Хөдөлмөрийн чадвараа алдсан 8 иргэнд хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэхний хүчинтэй хугацаа дууссан байсныг нь сунгуулан өгч ажилласан. Хөдөлмөрийн чадвараа алдсан 2 хүнд хөгжлийн бэрхшээлтэй хүний үнэмлэхийг шинээр олгуулсан.</p>

		Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийг шинэчлэн байгуулах	Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг байгуулах захирамжийн төслийг боловсруулсан.
9	Хэвлэн нийтлэх чиглэлээр	Иргэдийг Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээллээр хангах	<p>БГД-ийн Засаг даргын Хэвлэл мэдээллийн албанаас 2021.03.01- 2021-03.14 хооронд дүүргийн иргэдийг Засаг дарга, ЗДТГ-ын үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн мэдээ мэдээллээр хангах үндсэн үүргээ хэрэгжүүлж</p> <ul style="list-style-type: none"> • “Ажиглалтад байгаа иргэдэд хяналт тавих, харилцах системийг сайжруулахыг үүрэг болголоо”, • “Нийгмийн даатгалын дэвтэр бүрэн цахимжлаа”, • “Өнөөдөр баянгол дүүрэгт 13, 20 дугаар сургууль дээр рсг шинжилгээ авч байна”, • “Ө.Сумъяабаатар: бидний хийж хэрэгжүүлж буй ажил дундаа ямар нэгэн эргэлзээ байхгүйгээр түргэн шуурхай иргэддээ хүрэх хэрэгтэй”, • “Худалдаа үйлчилгээний 302 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллалаа”, • “Баянгол дүүрэгт албан байгууллагын ажилтнуудыг вакцинжуулалтад хамруулах ажил өрнөж байна”, • “Баянгол дүүрэг коронавируст “ковид-19” халдварын эсрэг вакцинжуулалтад 6662 иргэнийг хамруулаад байна” <p>гарчигтай нийт 7 мэдээллийг www.bgd.mn сайт болон Баянгол Дүүргийн Шуурхай Штаб https://www.facebook.com/shuurkhaishtab/ цахим хуудсаар иргэд, олон нийтэд мэдээлж ажиллалаа.</p> <p>Түүнчлэн, УОК, НОК, ДОК-ийн шийдвэрүүдийн хүрээнд Коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, урьдчилан сэргийлэхэд уриалсан зөвлөгөө зөвлөмж бүхий постер мэдээлэл, тандалт илрүүлгийн шинжилгээний үйл</p>

			<p>явц болоод, албан байгууллагуудын ажилтнуудыг нэгдсэн журмаар вакцинжуулалтад хамруулах, зохион байгуулалттай холбоотой мэдээлэл, зөвлөгөө зөвлөмж зэрэг нийт 91 /постер, зөвлөгөө, мэдээ/ мэдээллийг Баянгол Дүүргийн Шуурхай Штаб https://www.facebook.com/shuurkhaishtab/ цахим хуудсаар дамжуулаад байна.</p> <p>Мөн хэвлэл мэдээллийн бусад байгууллагууд, 10 гаруй сайтаар БГД-ийн Засаг дарга Ө.Сумъяабаатар: Бидний хийж хэрэгжүүлж буй ажил дундаа ямар нэгэн эргэлзээ байхгүйгээр түргэн шуурхай иргэддээ хүрэх хэрэгтэй”, “Баянгол дүүрэгт албан байгууллагын ажилтнуудыг вакцинжуулалтад хамруулах ажил өрнөж байна”, “Баянгол дүүрэг коронавируст “Ковид-19” халдварын эсрэг вакцинжуулалтад 6662 иргэнийг хамруулаад байна” зэрэг мэдээллүүдийг олон нийтэд мэдээлж ажиллалаа.</p>
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хэрэгжүүлэх зорилтын хүрээнд			
1	Бодлого боловсруулах чиглэлээр	<p>Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд хэлтэс, албадаас санал авч нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах</p> <p>Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний цахим санал асуулгыг 03 сарын 01-нээс 04 сарын 01-</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 85 заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөлд холбогдох 33 хэлтэс албадаас санал авч төлөвлөгөөний төслийг нэгтгэж дууссан. Хэрэгжүүлэх арга хэмжээний хяналт, шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулагдаж байна.</p> <p>Хэрэгжилт: 90%</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний цахим санал асуулгад дүүргийн хэмжээнд 18-аас дээш насны 132561 иргэн санал өгөхөөс 7202 иргэн санал өгсөн байна. Цахим санал асуулгын явц 5.4%-тай байна.</p>

		нийг хүртэл иргэдээс авах ажлыг зохион байгуулах	
		Хотын хөгжлийн индексийн 2020 оны тоон мэдээллийг нэгтгэх	Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийг батлгаажуулах ажлын хүрээнд 2021 оны 03 дугаар сарын 09-ны өдөр дүүргийн харъяа хэлтэс, алба болон 25 хорооны ажлын албанд албан бичиг хүргүүлээд байна. Дүүргийн 25 хорооноос шалгуур үзүүлэлтийн тоон мэдээллийг нэгтгэн боловсруулах ажил хэрэгжиж байна. Хэрэгжилт 40%
		Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах	Баянгол дүүргийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/78 тоот захирамжаар дахин төлөвлөн барилгажуулах төслийг эрчимжүүлэх, сууц өмчлөгч иргэдийн эрх ашиг, эд хөрөнгө, эрүүл мэнд, аюулгүй байдал, учирч болох эрсдлээс хамгаалах, үйлчилгээ явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хэрэгжилт: 30%
		Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Байгууллагын албан хаагчдын боловсруулж гаргасан захиргааны актын төслийг тогтмол хянаж, зөрчлийг нь арилгах, цаашид нэгдсэн стандартыг мөрдөн ажиллуулж хэвшүүлэх	2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар байгууллагын албан хаагчдын боловсруулсан 40 захирамжийн төсөл, 79 тушаалын төслийг хянаж, хяналтын дагалдах хуудас олгон, 7 албан хаагчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.
		Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Байгууллагын албан хаагчдын боловсруулж гаргасан захиргааны актын төслийг	2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 02 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар байгууллагын албан хаагчдын боловсруулсан 28 захирамжийн төсөл, 42 тушаалын төслийг хянаж, хяналтын дагалдах хуудас олгон, 3 албан хаагчдад хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан.

		<p>тогтмол хянаж, зөрчлийг нь арилгах, цаашид нэгдсэн стандартыг мөрдөн ажиллуулж хэвшүүлэх</p>	
		<p>Иргэний хуульд заасны дагуу байгууллагын албан хаагчдын боловсруулж гаргасан гэрээний төслийг тогтмол хянаж, зөрчлийг нь арилгах, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийн хуудас олгох</p>	<p>2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар байгууллагын албан хаагчдын гаргасан 7 гэрээний төслийг хянаж, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх зөрчил үүссэн тухай мэдэгдлийн хуудас олгосон.</p>
		<p>Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-дэхь хэсэгт заасны дагуу Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогч байгууллагуудын хамтын гэрээг хүлээн авч хянан хууль тогтоомжид нийцэж байвал бүртгэх</p>	<p>2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ажил олгогчоос 1 хамтын гэрээ, хэлэлцээр хянуулж, хуулийн дагуу бүртгэсэн болно.</p>
		<p>Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын системийн өргөдөл гомдлын модулийн ашиглалтыг эрчимжүүлж өргөдөл гомдлын шийдвэрлэлийг сайжруулах.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд Баянгол дүүрэгт 2021 оны 02 дугаар сарын 26-ээс 2021 оны 03 дугаар сарын 10-ний өдрийг дуустал нийт 284 өргөдөл, гомдол ирсэн байна. Нийт 284 өргөдлөөс шийдвэрлэсэн 135 буюу 48,0%, шийдвэрлэх шатандаа 149 буюу 52 %-тай шийдвэрлэгдсэн байна. Өргөдөлийг төрлөөр нь авч үзвэл хүсэлт-228 буюу 80 %, гомдол-54 буюу 19 %, талархал 2 буюу 1 %-ийг эзэлж байна.</p>

			<p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 14 цаг 51 минут буюу индексийн үнэлгээ 0,752 “В” үнэлгээгээр дүгнэгдсэн.</p> <p>Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл нийгмийн даатгал асуудлаар 35 %, албан хаагчдын ажлаас чөлөөлөгдөх болон архиваас лавлагаа авах хүсэлт нийт өргөдлийн 15 % -ийг эзэлж байна.</p> <p>Өргөдөл шийдвэрлэх явцад нийт 13 зөрчил үүссэн. Үүнд өдөрт нь багтааж хүлээж аваагүй 2, өдөрт нь багтааж шилжүүлээгүй 9, явцын тэмдэглэл хөтлөөгүй 2 зөрчил үүсч, зөрчил гаргаж байгаа хэлтсүүдийн өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтнүүдэд сануулга өгч ажилласан.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2021 оны 02 дугаар сарын 25-аас 2021 оны 03 дугаар сарын 10-ний өдрийг дуустал нийт 89 өргөдөл, гомдол ирсэн байна. Нийт 89 өргөдлөөс шийдвэрлэсэн 38 буюу 43,0%, шийдвэрлэх шатандаа 51 буюу 57 %-тай шийдвэрлэгдсэн байна. Өргөдөлийг төрлөөр нь авч үзвэл хүсэлт-77 буюу 87,0 %, гомдол-12 буюу 13 %-ийг эзэлж байна.</p> <p>Өргөдөл гомдлыг хандалтаар нь авч үзвэл албан хаагчдын ажлаас чөлөөлөгдөх болон архиваас лавлагаа авах хүсэлт нийт өргөдлийн 51 % -ийг эзэлж байна. Өргөдөл шийдвэрлэх явцад нийт 9 зөрчил үүссэн. Үүнд: өдөрт нь багтааж шилжүүлээгүй 9 зөрчил үүсч, зөрчил гаргасан мэргэжилтнүүдэд сануулга өгч ажилласан.</p> <p>Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 07 хоног 10 цаг 29 минут буюу индексийн үнэлгээ 0,752 “В” үнэлгээгээр дүгнэгдсэн.</p>
		<p>“Нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын иргэдтэй хийх</p>	<p>Дүүргийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/53 дугаар захирамжаар “Иргэдтэй хийх уулзалтын хуваарь”-ийг шинэчлэн батлуулсан.</p>

		уулзалтыг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох”	Коронавирус /ковид-19/ өвчний улмаас хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан иргэдтэй уулзалт зохион байгуулаагүй.
3	Бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр	Засаг дарга болон ЗДТГ-ын үйл ажиллагааны хүрээнд үүссэн захирамжлалын баримт бичгийн төслийг хэвлэмэл хуудсанд буулгах, бүрдэл хангуулах, бүртгэлжүүлэх	Захирамжлалын баримтын нэр төрлөөр бүртгэл үйлдэх, тоо хэрэгжилтээр Засаг даргын А захирамж-21, Засаг даргын Б захирамж-1, Тамгын газрын даргын А тушаал-9, Тамгын газрын даргын Б тушаал-74,
		Засаг дарга болон ЗДТГ-ын үйл ажиллагааны хүрээнд үүссэн харилцсан бичгийн төслийг хэвлэмэл хуудсанд буулгах, бүрдэл хангуулах, бүртгэлжүүлэх	Бүртгэл үйлдэх, цахим санд оруулах тоо хэрэгжилтээр явуулсан бичиг-117
		Мэргэшлийн зэргийн болзол хангасан албан хаагчдын судалгааг дүүргийн хэмжээнд гаргах, нэгтгэх, шалгах, дээд шатны байгууллагад хүргүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2020 оны А/62/78/89 дүгээр тушаалаар батлагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт”-ийг ханган мэргэшлийн ахлах зэрэг олгох 8 байгууллагын 8 албан хаагчдын мэдээллийг, Архивын Ерөнхий газрын даргын 2020 оны А/134 дүгээр тушаалаар батлагдсан “Тэргүүлэх, зөвлөх зэрэг олгох шалгалтын журам”-ын шалгуур хангасан 1 албан хаагчийн баримт бичгийг Нийслэлийн Архивын газарт хүргүүлж ажиллав.
		Дүүргийн архивын эх үүсвэрийн байгууллагуудын төрийн архивт цахим нөхөн бүрдүүлэлт хийх ажилд хяналт тавих, батлах	Дүүргийн харьяа байгууллагуудаас 19 байгууллагын 1952 баримт, 3456 хуудас, 4.41 gb баримтыг төрийн архивын цахим сан хөмрөгт шивж оруулсаныг нэг бүрчлэн шалгаж баталгуулж ажиллалаа.

		<p>Нөөцийн мах худалдан борлуулах хүнсний дэлгүүрүүдэд сургалт зохион байгуулах</p>	<p>2021 оны хүн амын хаврын хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махыг худалдан борлуулах нийт 63 хүнсний дэлгүүрүүдэд Улаанбаатар хотын Захирагчийн ажлыг алба, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нийслэлийн татварын газар, дүүргийн татварын газар, дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран 2021 оны 03 дугаар сарын 04,05-ний өдрүүдэд халдвар хамгааллын дэглэмээ сахиулан сургалт зохион байгуулж, Улсын Онцгой комиссоос гаргасан "Түр журам"-ыг аж ахуйн нэгжүүдэд танилцуулж ажиллалаа. Мөн 2021 оны 03-р сарын 05-ны дүүргийн Татварын хэлтэстэй хамтран сургалтанд хамрагдаагүй 26 аж, ахуй нэгжид сургалт зохион байгуулсан.</p>
		<p>Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн хурлыг зохион байгуулах</p>	<p>Худалдаа, үйлчилгээг зохиоцуулах зөвлөлийн хурлыг 2021 оны 03 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Хурлаар тамхи худалдаалах тусгай зөвшөөрөл хүссэн 24 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, 14, 15, 20 дугаар хорооны ил задгай худалдаа үйлчилгээ, ТҮЦ-ийн хүсэлт иргэдийн асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэн ажиллалаа.</p>
		<p>"Манай хороо Миний гудамж" аян зохион байгуулах</p>	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2021 оны А/27 дугаар тушаалын дагуу дүүргийн хэмжээнд тус аяны хэрэгжилтийг зохион байгуулах дэд ажлын хэсгийг дүүргийн Засаг даргын А/70 дугаар захирамжаар зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна.</p>
		<p>Нийтийн эзэмшлийн усан оргилуурт үзлэг шалгалт зохион байгуулах</p>	<p>Нийтийн эзэмшлийн усан оргилуурын эвдрэл гэмтэлд үзлэг шалгалт зохион байгуулж, арчлалт засвар үйлчилгээ хариуцах байгууллагыг шалгаруулах техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулах бэлтгэл хангуулсан.</p>

4	Төрийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр	Дүүргийн архивын сан хөмрөгөөс иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар олгох, түр ашиглуулах	Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу цахим сангаас лавлагаа хуулбар олгосон. хуулбарын тоо: Олгосон хуулбарын тоо:2 Хуудасны тоо: 2 Хугацаа: өдөрт нь Түр олгосон баримт:0
		Байгууллагын архивын сан хөмрөгөөс иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар олгох, түр ашиглуулах	Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу цахим сангаас лавлагаа хуулбар өдөрт нь, цаасан суурьтай баримтаас ажлын 1-5 хоногт, тоо хэрэгжилтээр Олгосон хуулбарын тоо:27 Хуудасны тоо: 47 Хугацаа: өдөрт нь Түр олгосон баримт:11
		Байгууллагын бичиг хэргээс иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар олгох,	Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу лавлагаа хуулбар өдөрт нь, тоо хэрэгжилтээр Олгосон хуулбарын тоо:6
		Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 107 байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавих	Бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног, шийдвэрлэлтийн дундаж хувь 92%, тоо хэрэгжилтээр. Тайлант хугацаанд ирсэн бичгийн тоо-1262, шийдвэрлэлтийн дундаж хугацаа-6,06 хоног, шийдвэрлэлтийн дундаж хугацаа-99,1%
		Засаг даргын Тамгын газрын хэмжээнд нийслэлийн удирдлагын нэгдсэн систем /erp.ulaanbaatar.mn/-ийн албан хэрэг хөтлөлтийн дэд систем /edoc.ulaanbaatar.mn/-ээр ирсэн, цаасаар байгууллагад ирсэн бичгийг хүлээн авах, бүртгэх,	Бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 9 хоног, шийдвэрлэлтийн дундаж хувь 92%, тоо хэрэгжилтээр. Тайлант хугацаанд ирсэн бичгийн тоо-156, шийдвэрлэлтийн дундаж хугацаа-0,94 хоног, шийдвэрлэлтийн дундаж хувь-100%

	<p>шилжүүлэх шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, тайлагнах, холбогдох арга хэмжээг авч ажиглах;</p>		
<p>Гурав. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд</p>			
<p>Дүүргийн иргэдийн санал, гомдол, хүсэлт хүлээн авах, иргэдэд төрийн үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилготой 18001222 тусгай дугаараар 3 дугаар сарын 01-ний өдрөөс 12-ны өдрийн байдлаар нийт 342 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажиглалаа. /24 цагаар/</p>	<p>Дүүргийн иргэд, байгууллагад төрийн үйлчилгээний нэгдсэн мэдээллийг хүргэх "Лавлах үйлчилгээ"-г хүргэж ажиглах.</p>	<p>Төрийн үйлчилгээт иргэдэд ил тод, хүрдэн шүүрхай, чанартай, хүртээмжтэй үзүүлэх чиглэлээр</p>	<p>1</p>
<p>Иргэдэд үйлчлэх төв нь 3 дугаар сарын 01 - 12-ны өдрүүдэд 25 иргэнд хууль, эрх зүй болон эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиглалаа. Үүнээс хууль, эрх зүй чиглэлээр 6 иргэнд, эрүүл мэнд, нийгмийн даатгалын чиглэлээр 10 иргэнд, нийгмийн халамжийн чиглэлээр 6 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. Ажилд орох хүсэлтэй 3 иргэнийг ажиглаж зурчлан хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн нэгдсэн санд бүртгүүлэн ажигласан. Мөн Баянгол дүүрэг, Баянгол дүүргийн иргэдэд үйлчлэх төв гэсэн цахим хуудсуудад ирүүлсэн 84 иргэний асуултад тухай бүр хариулт, зөвлөгөө өгч ажигласан. /Ковид-19 цар тахлын хөл хоригтой холбоотойгоор төвөөр ирж хуулийн зөвлөгөө авах иргэдийн тоо эрс буурсан./</p>	<p>"Иргэдэд үйлчлэх төв"-өөр дүүргийн иргэдэд эрх зүйн зөвлөгөө, тусалгаа үзүүлэх</p>		

		Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэлт	Тохижилтын ажлын барьцаа хөрөнгө чөлөөлүүлэх хүсэлт ирүүлсэн Буян нэмэх интер ХХК-ийн гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь үзлэг шалгалт зохион байгуулж, тодорхойлолтыг НХОГ-т, сургууль, цэцэрлэгийн гадна орчны тохижилтын судалгааг ирүүлсэн судалгааны маягтын дагуу нэгтгэн ХСОАБХЗГ-т, 18 дугаар хорооны иргэдээс ирүүлсэн тохижилт хийлгэх хүсэлтийн дагуу судалгаа хийж, дүүргийн ГЗБА-нд газар чөлөөлөх тухай хүсэлтийг тус тус хүргүүлж ажиллалаа. Мөн хороодоос ирүүлсэн Манай хороо Миний гудамж аяны төлөвлөгөөг нэгтгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.
		Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, батламж олгох	Материал бүрдүүлж, хүсэлт гаргасан худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ахуйн нэгж, байгууллагийн хүсэлтийг дүүргийн Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлд танилцуулж гэрээ байгуулж, нийт 285 батламж олгож ажиллалаа.
		ЗДТГ-ын үйл ажиллагааны хүрээнд үүссэн захирамжлалын баримт бичгийг цахимжуулах	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны эрхлэх ажлын хүрээнд үүссэн захирамжлалын баримтаас /А захирамж Боть 5-Боть 8/ 4 хадгаламжийн нэгж, нийт 345 МВ баримтад Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/452 дугаар захирамжаар батлагдсан стандартыг хангуулан цахим хувь үйлдэж ажиллалаа.
		ЗДТГ-ын 2020 оны үйл ажиллагааны хүрээнд үүссэн баримтаар байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх	Тайлант хугацаанд хуваарийн дагуу 2020 оны 150 хадгаламжийн нэгжээр нөхөн бүрдүүлэлт хийсэн байна. Байнга хадгалах-25 хн, түр хадгалах-125, 70 жил хадгалах-0
Дөрөв. Цаг үеийн асуудлын хүрээнд			
1		Дүүргийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хөл хорионы дэглэм тогтоосноос	Баянгол дүүргийн ЗДТГ-ын хэрэгжүүлж буй ажлын хүрээнд Иргэдэд үйлчлэх төв нь 18001222 дугаарын утсаар дүүргийн иргэдээс 24 цагаар дуудлага хүлээн авч

		хойш ажил нь зогсч, орлогогүй болсон иргэдийн дуудлага мэдээллийг 18001222 дугаараар хүлээн авч хүнс хүргэж ажиллах;	шаардлагатай нөхцөлд хүнсний хангамж хүргэж ажиллаж байна. 03 дугаар сарын 09-ний өдөр дүүргийн 25 дугаар хорооны хөл хорио тогтоогдсон 301 дүгээр байрны 13 өрхөд хүнсний тусламжийн багцыг халдвар хамгааллын дэглэм баримталж хүргэж өгч ажилласан. Мөн хүнсний тусламж нэн шаардлагатай 2 дугаар хороо, 5 дугаар хороо, 19 дүгээр хорооны 3 өрхөд тус тус хүнсний багц хүргэсэн.
		Боловсролын салбарын алба хаагчдыг вакцинжуулалтад хамруулах.	Төрийн өмчийн өрөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 5200 гаруй албан хаагчдыг 03 дугаар сарын 10,11,12-ны өдрүүдэд вакцинжуулалтанд хамруулахаар хуваарийг гарган 03 дугаар сарын 12-ны байдлаар нийт 1531 албан хаагчдыг хамруулж ажиллаа.

Тав. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт


1	“Стратегийн, гамшгийн болон орон нутгийн хүнсний бодит нөөцийг тодотгох.	Стратегийн, гамшгийн болон орон нутгийн хүнсний бодит нөөцийн судалгааг гаргах ажлын хүрээнд тус дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хүнсний 8 дэлгүүр, худалдааны 10 төв, хүнсний 7 үйлдвэрээс 12 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн мэдээг өдөр бүрээр авч, тодотгол хийж мөн үнийн өсөлтөл тогтмол хяналт тавьж, судалгаа, мэдээг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэн ажиллаж байна.
2	Төлөвлөгөөнд тодотгол хийх	Дүүргийн Онцгой Комиссын Хүнсээр хангах алба Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалыг тус тус үндэслэн хүнсээр хангах төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг зохион байгуулж байна.
3	Нийслэлийн үйлдвэрлэлийн бодлогын хөгжлийн асуудлаар санал боловсруулах,	Нийслэлийн Үйлдвэр Инновацийн газраас 2021.02.16-ны өдөр ирүүлсэн 02/37 дугаар албан бичгийн хүрээнд үйлдвэр эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийг дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв болон 25 хорооны ажлын алба, Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн үүсгэсэн дата баазад тулгуурлан шинэчлэл хийж, хүргүүлэн ажиллалаа.

	бодлогын хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгох	
4	Мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт хамгаалалт, албан хэрэг хөтлөлт, архивын талаар	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.20 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 01 дүгээр зарлигаар батлагдсан "Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрэм"-ийн 2.1.2.16 дахь хэсгийг тус тус үндэслэн Зэвсэгт хүчний Стратегийн Команд штабын сургуулийн үед мэдээллийн аюулгүй байдал, нууц хадгалалт, хамгаалалтыг ханган арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж тайлан мэдээг албан хэрэг хөтлөлтийн дагуу боловсруулан 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабт хүргүүлсэн. Цэргийн штабаас 2021 онд зохион байгуулах сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдөр 9 мм ПМ гар бууны буудалгын сургалтад оролцсон.


ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА


ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН,
ТАЙЛАН МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.НАРАНГЭРЭЛ



Б.МӨНГӨНХУЯГ



Б.ГЭРЭЛМАА